

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 3 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 03 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
1	<p>Үүрэг, даалгавар НЭГ: Эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хүндрэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх ✓ Гадаад томилолтуудыг зогсоох ✓ Нийгмийн баталгаа, хөтөлбөр төслүүдийг түр зогсоох. ✓ Машин, техник, тоног төхөөрөмжийг худалдан авахгүй байх ✓ Зарим хөрөнгө оруулалт ✓ Бусад гэх мэт 			90
2	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эрчимжүүлж хийгдсэн ажлын арга хэмжээнүүд:			50
	Үүрэг, даалгавар ХОЁР: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, танилцуулах			

	<ul style="list-style-type: none"> • Нийслэлээс эрх шилжиж ирсэн НОНХС хөрөнгө мөн Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх "Нийтийн зориулалттай орон сууцнуудын фасад болон дээвэр засварын ажил"-ын ажлын даалгавар болон зураг төслүүдийг дүүргийн ХААА-нд хүргүүлж ажилласан. • Дүүргийн ХААА-нд боловсролын салбарын засварын зургийн 19 ажлын даалгавар хүргүүлсэн. • Дүүргийн ХААА-нд дөрвөн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг хүргүүлсэн. Хэлтэс, албадууд техникийн тодорхойлолтоо ирүүлээгүй байна. • Мөн Нийслэлийн Замын хөгжлийн газарт замын ажлын зургийн архитектур төлөвлөлтийн даалгавар хүсэж 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/591 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. • Дээвэр фасадын ажлын зураг төсвийн 29 ажлын даалгавар хийгдсэн бөгөөд дүүргийн Засаг даргад танилцуулан, санал хүлээж байна. 		
<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Хөрөнгө оруулалтын ажлууд болон Сэлбэ төслийн газар чөлөөлөлт, цэвэрлэгээний ажлуудыг эрчимжүүлж ажиллах.</p>			50
<p>3</p>	<p>"Сэлбэ" дэд төвийн бүтээн байгуулалтын талбайг бэлтгэх ажлын хүрээнд чөлөөлөгдсөн нэгж талбарын цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн ажлыг 2025 оны 02 дугаар сараас эхлүүлэн эрчимтэйгээр явагдаж байна. Тухайн бүсийн цэвэрлэгээ үйлчилгээг дүүргийн Чингэлтэй Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ хариуцан ажиллаж байгаа ба нийт 30 гаруй техник хэрэгсэл ажиллаж байна. Мөн тухайн бүсэд өдөр тутмын хяналтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс тогтмол хяналт тавин ажиллаж байна.</p>		
<p>4</p>	<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн хэмжээнд гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах</p>		90
	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гудамж талбайд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн 5 дахь өдөр бүр нэгдсэн эргүүлийг зохион байгуулж, ажлын өдрүүдэд явган эргүүлийн 5 чиглэлд 10 алба хаагчийг ажиллуулан давхардсан тоогоор 70 алба хаагч 420 хүн/ цаг үүрэг гүйцэтгэж, давхардсан тоогоор 123 байгууллага аж ахуйн нэгжийг шалган 4 зөрчил илрүүлсэн. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах АСАП санд эрэн сурвалжлалт зарлагдсан 5 этгээдийг олж тогтоон, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж биеэ удирдах, жолоодох чадваргүй явсан 13 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 3 иргэнийг эмнэлгийн байгууллагад шилжүүлж учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлсэн. Мөн Авто эргүүлийн 6 чиглэлийн алба хаагчид өглөө, оройн цагаар хүн ихээр цуглардаг,</p>		

	автобусны буудал, зах худалдааны төв зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд хяналт тавиулан давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлдэг 13 хаяг байршилд алба хаагчаар биечлэн хяналт тавьж дуудлага мэдээллийг бууруулах чиглэлээр нийтэд сурталчлан, түгээн ажилласан.	
Үүрэг, даалгавар ТАВ:	Нийслэлийн хэмжээнд хог хаягдлыг цэвэрлэх, угаах ажлыг зохион байгуулах захирамжийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих	
5	<p>Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулан эхлүүлээд байна.</p> <p>Цэвэрлэгээний 1 дүгээр ээлж: Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн (хайс, хашлага, ногоон байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, арчлалт хамгаалалт, цэнэг усалгаа, хүүхдийн тоглоомын талбай, автобусны буудлын цэвэрлэгээ, үерийн далан суваг, гуу, жалга, дагуух түүвэр цэвэрлэгээ) зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан.</p> <p>2025 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдийн цэвэрлэгээгээр:</p> <ul style="list-style-type: none"> - Дүүргийн ЗДТГ-ын байрны гаднах талбайд хөөстэй угаалга хийж өнгө үзэмжийг сэргээсэн Авто зам дагуух хайс, хашлаганы өнгө үзэмжийг сэргээх хөөстэй угааж цэвэрлэх (Нийт зам талбайн 64 үйлчлэгч нар нийт 38366 у/м хайс, хашлага) - Ногоон байгууламжийн цэвэрлэгээ, үйлчилгээ арчлалт хамгаалалт, усалгаа (нийт 21 ажилтан, усалгааны 1 техник хэрэгсэл) Цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, эд хогшлын хөөстэй угаалга (нийт 4 цэцэрлэг хүрээлэн, 68 бичил цэцэрлэгийн хөөстэй угаалга) - Автобусны буудлуудын хөөстэй угаалга (нийт 56 автобусны буудал) - нийт 49 хог тээврийн авто машин (1-24 дүгээр хороодод нийт 289 рейсээр, 732 тонн хог хаягдал) - Зам талбайн 132 үйлчлэгч Иргэдийн бүлгийн 25 ажилтан нар нийт 286,534м2 талбайг (түүвэр цэвэрлэгээ буюу үерийн далан суваг, гуу жалга, дагуух үүсмэл хог хаягдал) хуваарийн дагуу цэвэрлэн ажиллаж байна. - Авто замын нуух цэвэрлэх тусгай зориулалтын 2 техник хэрэгсэл (томоохон авто замуудад)-ээр тус тус зохион байгуулан ажилласан. 	90
Үүрэг, даалгавар ЗУРГАА:	Нохой, муур устгах ажлаа эрчимжүүлж, үр дүн гаргаж ажиллах	
6	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/345 тоот захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эзэнгүй золбин муур, нохой устгалын ажлыг батлагдсан хуваарийн дагуу эрчимжүүлсэн устгалын ажлыг 2025 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдөр нийт устгалын 2 байгууллага 9 машин, 9 анчин, 9 ачигчтайгаар ажилласан.</p> <p>- Их булаг АТҮК ХХК нийт 239 нохой, 23 муур</p>	100

	- Өлтэй ХХК нийт 223 золбин нохой буюу нийт 462 нохой, 23 муурыг тус тус устган ажилласан.		
Үүрэг, даалгавар ДОЛОО: 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлж ажиллах			
7	<p>2025 оны 03 дугаар сарын 21-ний байдлаар өссөн дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Улсын төсөвт 22.441.622.94 мянган төгрөг төвлөрүүлэхээс 31.447.074.12 мянган төгрөг төвлөрүүлж 140.13% ✓ Нийслэлийн төсөвт 6.490.087.76 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3.867.551.30 мянган төгрөг төвлөрүүлж 59.59% <p>Дүүргийн төсөвт 63.664.222,80 мянган төгрөг төвлөрүүлэхээс 47.173.780.65 мянган төгрөг төвлөрүүлж 74.10%-ийн биелэлттэй ажиллаж байна.</p>		90
Үүрэг, даалгавар НАИМ: Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын орчин тойрны өнгө үзэмжийг сэргээх ажлыг эрчимжүүлж ажиллах			
8	<p>Дүүргийн 1 дүгээр хороо "Монтел" худалдааны төвийн баруун талд баригдаж байгаа барилгын хамгаалалтын хашаа нь явган хүний зам руу орж баригдсан тул энэ талаар дүүргийн Газар зохион байгуулалтын албанд 3/306 тоот албан бичгээр хүргүүлсэн. Ард кино театрын хашаа нуран, хог хаягдал ихээр үүсч, архины хамаарал бүхий иргэд цугларч гэмт хэрэг гарах магадлал бүхий орчин бүрдээд байгааг Нийслэлийн Байгаль орчны газарт албан бичгээр уламжилсан. Тус байгууллага нь үүний хүрээнд эзэмшигч "Од театр" ХХК нь зөрчил үйлдсэнийг тогтоон Зөрчлийн тухай хуулийн 6.1 дэхь зүйлийн 7.2 дахь заалтад заасны дагуу шийтгэл оногдуулж ажилласан.</p>		70
Үүрэг, даалгавар ЕС: Нийслэлийн хэмжээнд Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлж, үерийн хамгаалалтын далан сувгийн лаг шаврыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах			
9	<p>Тус дүүргийн 8 дугаар хороо, Зүүн тасган орчимд халиа тошин үүссэн 126м3 мөсийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр 4 цагийн хугацаанд 1 экскаватор, 7 хово автомашинаар зөөж тээвэрлэсэн. 17 дугаар хороо, Сурагчийн 64-р гудамж орчимд 130 у/м суваг татаж, гарсан мөсөөр далан босгох ажил, 20 дугаар хороо, 400 у/м суваг татаж, гарсан мөсөөр далан босгох ажлуудыг 2025.03.19-ний өдөр 8 цагийн хугацаанд 1 экскаватороор ухаж ажилласан. 24 дүгээр хороо, Шадивлан, зуун мод орчимд 5 у/м шороон далан сэтлэх, 36 м3 шороогоор 16 у/м шороон далан босгох, Гүнт орчимд 25 у/м суваг татах ажлыг 13 цагийн хугацаанд 1 экскаватор, 2 хово автомашинаар гүйцэтгүүлсэн.</p> <p>2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо Гүнтийн давааны зам дагуу шар ус урсаж байсныг 2 газарт сэтэлж жалга руу оруулж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. Зуун мод 2 хэсэгт Сэлбэ голоос ус хальж</p>		90

	байсныг шороо асгаж шороон далан босгож ажилласан. Ар согоотын далангийн ус нэвчиж тогтоол үүссэн байсныг шуудуу татаж гол руу урсгасан. Дүүргийн 117 дугаар сургуулийн шинэ гүүрний баруун хойд хэсэгт ус тогтсон байсныг даланг сэтэлж урсгасан. Онцгой байдлын хэлтсийн 1 алба хаагч 1 тээврийн хэрэгсэл, Чингэлтэй тохижилт үйлчилгээний ХХК-ны 1 албан хаагч, 24 дүгээр хорооны Засаг дарга нар тус тус зохион байгуулан ажилласан.		
Үүрэг, даалгавар АРАВ: Үерийн эрсдэлтэй бүсэд байгаа айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах			
10	2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран дүүргийн 17, 20 дугаар хороо болон зуслангийн 24 дүгээр хороодод шар усны үерт өртсөн нийт 32 айл өрхөд Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын газар чөлөөлөх мэдэгдэх хуудас өгч ажилласан.		50
Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 болон Нийслэлд хэрэгжүүлэх 24 мега төслийн талаар НЗДТГ, нутгийн захиргааны болон бусад байгууллагын албан хаагчдад танилцуулах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах			
11	"Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-ний төслийг дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэдэд танилцуулах хуваарийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 3/455 дугаарын албан бичгээр хүргүүлж, 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын Хурлын танхимд зохион байгуулж хороодын Засаг дарга нар 20 иргэдийн хамт оролцсон. Мөн "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040" танилцуулгыг нийт албан хаагчдад 2025 оны 03 дугаар сарын 12-ны өглөөний 07:00 цагт "Бишрэлт" зочид буудалд, мөн 14, 15, 16, дугаар хороодын нийт 180 гаруй иргэдэд 03 дугаар сарын 18-ны өдөр 72 дугаар сургууль дээр тус тус танилцуулсан.		70
Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, цахим хуудас мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.			
12	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудас болон shilen.dans.mn системд "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн нээлттэй байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр үнэлгээ хийлгэн ажиллаж байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний		90

<p>газраас 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан нээлттэй мэдээллийн <i>shilen.gov.mn</i> системд мэдээлэл оруулах албан хаагчийг чадваржуулах сургалтад Засаг даргын Тамгын газрын 2 албан хаагч хамрагдсан.</p>	<p>77.5%</p>
---	--------------



ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ЛХАГВАСҮРЭН

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ

(Handwritten signatures in blue ink)